



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Харилцаа холбооны зах зээлийн статистик эмхэтгэл

2025



Эмхэтгэлийг боловсруулсан
Харилцаа холбооны зохицуулах хорооны
Зах зээл үнэ тарифын зохицуулалтын газар
Судалгаа, шинжилгээний хэлтэс
www.crc.gov.mn
11-304258

2026 он

Агуулга

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт	iii
Зурган мэдээллийн жагсаалт	v
1. Үндсэн үзүүлэлтийн танилцуулга	1
2. Тусгай зөвшөөрөл	4
3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	6
3.1 Харилцаа холбооны үйл ажиллагааны орлого	6
3.2 Төсөвт төвлөрүүлсэн орлого	7
3.3 Хөрөнгө оруулалт	8
4. Харилцаа холбооны сүлжээ	9
4.1 Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт	10
4.2 Харилцаа холбооны сүлжээний урт	11
4.3 Улс хоорондын сүлжээний үйлчилгээ	12
4.4 Улс хоорондын транзит үйлчилгээ	13
4.5 Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ	13
5. Үүрэн холбооны үйлчилгээ	14
5.1 Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт	15
5.2 Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо	16
5.3 Үүрэн холбооны ачаалал	23
5.3.1 Ярианы ачаалал	23
5.3.2 Мессеж ба дата хэрэглээ	23
6. Суурин интернэт үйлчилгээ	25
6.1 Суурин интернэт үйлчилгээний орлого	26
6.2 Суурин интернэт хэрэглэгчийн тоо	27
6.3 Суурин интернэтийн хэрэглээ	29
7. Суурин телефон үйлчилгээ	30
7.1 Суурин телефон үйлчилгээний орлого	31
7.2 Суурин телефон хэрэглэгчийн тоо	32
7.3 Суурин телефон ярианы ачаалал	34
8. Өргөн нэвтрүүлэг - Олон суваг дамжуулах үйлчилгээ	35
8.1 Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого	36
8.2 Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо	37
9. Телевизийн үйлчилгээ	40
10. Радиогийн үйлчилгээ	44
11. Шуудангийн үйлчилгээ	46
11.1 Шуудангийн үйлчилгээний орлого	47

11.2	Шуудангийн илгээмж солилцоо	48
11.2.1	Дотоодын шуудангийн үндсэн үйлчилгээний илгээмж солилцоо	49
11.2.2	Улс хоорондын шуудангийн илгээмж солилцоо	50
12.	Хүний нөөц	51
13.	Домэйн нэр	52

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн шийдвэрийн мэдээлэл, оноор	4
Хүснэгт 2. Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо, төрлөөр	5
Хүснэгт 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого,	6
Хүснэгт 4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, үйл ажиллагааны чиглэлээр	8
Хүснэгт 5. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, тусгай зөвшөөрлийн төрлөөр	9
Хүснэгт 6. Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, үйлчилгээний хүртээмжээр, 2025	9
Хүснэгт 7. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр	11
Хүснэгт 8. Дамжуулах сүлжээний урт (км), төрлөөр	11
Хүснэгт 9. Харилцаа холбооны хот, хот хоорондын дамжуулах сүлжээний урт (км), оноор	11
Хүснэгт 10. Улс хоорондын нийт транзит урсгал ба орлогын хэмжээ, оноор	13
Хүснэгт 11. Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэгчдийн орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр	14
Хүснэгт 12. Сансрын холбооны интернэт хэрэглэгчийн тоо, оноор	14
Хүснэгт 13. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд эзлэх хувь	14
Хүснэгт 14. Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр	15
Хүснэгт 15. Үүрэн холбооны үндсэн үйлчилгээний орлого, оноор	15
Хүснэгт 16. Үүрэн холбооны нэвтрэлтийн түвшин	17
Хүснэгт 17. Хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоо, оноор	17
Хүснэгт 18. Хөдөлгөөнт өргөн зурвасын смарт бокс ашиглан үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоо	18
Хүснэгт 19. Үүрэн холбооны бааз станцын тоо, технологийн төрлөөр	19
Хүснэгт 20. Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо бүс, байршлаар, 2025 он	20
Хүснэгт 21. Үүрэн холбооны үйлчилгээний нэг хэрэглэгчийн сарын дундаж дата хэрэглээ	25
Хүснэгт 22. Суурин интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор	25
Хүснэгт 23. Суурин интернэт үйлчилгээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 4 жилээр	26
Хүснэгт 24. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, оноор, гэрээт хурдаар	28
Хүснэгт 25. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр	29
Хүснэгт 26. Суурин интернэт үйлчилгээний дата хэрэглээ, оноор	30
Хүснэгт 27. Суурин телефон үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор, 2025 он	31
Хүснэгт 28. Суурин телефон үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт,	31
Хүснэгт 29. Суурин холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо, оноор	33
Хүснэгт 30. Суурин холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо, төрлөөр	33
Хүснэгт 31. Суурин телефон хэрэглэгчийн тоо, хэрэглэгчийн төрлөөр, 2025 он	34
Хүснэгт 32. Суурин телефон хэрэглэгчийн тоо, байршлаар, оноор	34
Хүснэгт 33. Суурин телефон хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр	34
Хүснэгт 34. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор, 2025 он	35

Хүснэгт 35. Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 4 жилээр	36
Хүснэгт 36. АйПиТВ үйлчилгээний хэрэглэгчийн тоо, төрлөөр	38
Хүснэгт 37. Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр, 2025 он	39
Хүснэгт 38. Телевизийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, хамрах хүрээгээр, 2025 он	41
Хүснэгт 39. Телевизийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт,	41
Хүснэгт 40. Телевизийн үйлчилгээний 2025 оны орлого /Тэрбум төгрөг/	42
Хүснэгт 41. Телевизийн үйлчилгээний орлогын бүтэц	42
Хүснэгт 42. Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн 2025 оны орлогын бүтэц	43
Хүснэгт 43. Арилжааны телевизүүдийн 2025 оны орлогын бүтэц	43
Хүснэгт 44. Радиогийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, хамрах хүрээгээр	44
Хүснэгт 45. Радиогийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр	45
Хүснэгт 46. Радиогийн үйлчилгээний 2024 оны орлого, байршлаар	45
Хүснэгт 47. Радиогийн үйлчилгээний орлогын бүтэц, 2025 он	45
Хүснэгт 48. Шуудангийн тусгай зөвшөөрлийн тоо	46
Хүснэгт 49. Шуудангийн сүлжээ байгуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт 2025	46
Хүснэгт 50. Улс хоорондын илгээмжийн үйлчилгээ үзүүлж буй чиглэл, үйлчилгээ эрхлэгчийн тоо, 2025 он	46
Хүснэгт 51. Шуудангийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр	47
Хүснэгт 52. Нийт шуудангийн илгээмж солилцооны тоо	48
Хүснэгт 53. Дотоодын шуудангийн үндсэн үйлчилгээний илгээмж солилцоо, илгээмжийн төрлөөр, 2025 он	49
Хүснэгт 54. Дотоодын шуудангийн үндсэн үйлчилгээний илгээмж солилцоо, оноор	49
Хүснэгт 55. Дотоодын буухиа шуудан солилцоо, оноор	49
Хүснэгт 56. Улс хоорондын шуудангийн илгээмж солилцоо, илгээмжийн төрлөөр, 2025 он	50
Хүснэгт 57. Улс хоорондын шуудан солилцоо, чиглэлээр, 2025 он	50
Хүснэгт 58. Улс хоорондын шуудан солилцооны тоо	50
Хүснэгт 59. Улс хоорондын буухиа шуудан солилцоо	50
Хүснэгт 60. Нийт ажилтны тоо, салбар болон үйлчилгээний төрлөөр, оноор	51
Хүснэгт 61. Домэйн нэр бүртгэгч байгууллагын жагсаалт	52
Хүснэгт 62. Монгол Улсын бүртгэгч байгууллагуудын олгосон нийт домэйн нэрийн тоо, 2021-2025 он	53
Хүснэгт 63. Дэд домэйн нэрийн тоо, оноор	53
Хүснэгт 64. Домэйн нэрийн тоо, бүртгэгч байгууллагаар	54
Хүснэгт 65. MN, .MON домэйн нэрийн тоо, бүртгэгч байгууллагаар	55
Хүснэгт 66. Идэвхтэй ба идэвхгүй MN, MON домэйн нэрийн тоо, оноор	56

Зурган мэдээллийн жагсаалт

Зураг 1. Зөвшөөрлийн тоо, оноор.....	4
Зураг 2. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, 2023-2025 он.....	6
Зураг 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, оноор	6
Зураг 4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, оноор	7
Зураг 5. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, оноор	8
Зураг 6. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, оноор	10
Зураг 7. Хот хоорондын шилэн кабелийн сүлжээний эзэмшил, 2025	12
Зураг 8. Интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгчдийн нийт урсгалын багтаамж: Гбит/сек	13
Зураг 9. Үүрэн холбооны үйлчилгээний орлого, оноор.....	15
Зураг 10. Үүрэн холбооны нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU)	16
Зураг 11. Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо, оноор	16
Зураг 12. Хэрэглэгчийн төлбөрийн нөхцлөөр зах зээлд эзлэх хувь, оноор	17
Зураг 13. 3G, 4G/LTE, 5G хэрэглэгчийн тоо	18
Зураг 14. Үүрэн холбооны бааз станцын тоо, технологийн төрлөөр	19
Зураг 15. Үүрэн холбооны 3G нэвтрэлтийн хувь, аймгаар, 2025 он	21
Зураг 16. Үүрэн холбооны 4G/LTE нэвтрэлтийн хувь, аймгаар, 2025 он	21
Зураг 17. M2M хэрэглэгчийн тоо, оноор	22
Зураг 18. Ухаалаг төхөөрөмж хэрэглэгчийн тоо	22
Зураг 19. Үүрэн холбооны сүлжээн дэх ярианы ачаалал, сая минут	23
Зураг 20. Үүрэн холбооны сүлжээнд илгээсэн мессеж, сая ширхэг.....	24
Зураг 21. Хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн дата ачаалал, технологийн төрөл, оноор - Терабайт (ТВ)	24
Зураг 22. Суурин интернэт үйлчилгээний нийт орлого.....	26
Зураг 23. Интернэтийн үйлчилгээний орлогын бүтэц, 2025 он	26
Зураг 24. Суурин интернэт хэрэглэгчийн тоо.....	27
Зураг 25. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, байршлаар	27
Зураг 26. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр	28
Зураг 27. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, гэрээт хурдаар	28
Зураг 28. Суурин интернэт үйлчилгээний нэг хэрэглэгчийн сарын дундаж хэрэглээ, оноор	30
Зураг 29. Суурин телефон үйлчилгээний нийт орлого	31
Зураг 30. Суурин телефон холбооны орлогын бүтэц, 2025 он	32
Зураг 31. Суурин телефон үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU), оноор.....	32
Зураг 32. Суурин холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо, оноор.....	33
Зураг 33. Суурин холбооны ярианы ачаалал, оноор.....	35
Зураг 34. Олон суваг дамжуулах үйлчилгээний нийт орлого	36
Зураг 35. Олон суваг дамжуулах үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU), оноор.....	36
Зураг 36. Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоо, оноор	37
Зураг 37. Олон суваг дамжуулах хэрэглэгчийн тоо, байршлаар, оноор.....	37
Зураг 38. Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгч, технологийн төрлөөр	37
Зураг 39. Олон суваг дамжуулах хэрэглэгчийн тоо, байршил ба технологиор, 2025 он.....	38
Зураг 40. АйПиТВ үйлчилгээний нийт хэрэглэгчийн тоо, оноор.....	38
Зураг 41. АйПиТВ хэрэглэгчийн тоо, байршлаар, оноор.....	39
Зураг 42. Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн орлого	41
Зураг 43. Радиогийн үйлчилгээний орлого, оноор.....	44

Зураг 44. Шуудангийн нийт үйлчилгээ эрхлэгчид болон Монгол Шуудан ХК-ийн орлогын харьцуулалт, оноор	47
Зураг 45. Шуудангийн үйлчилгээний орлогын бүтэц, эзлэх хувиар	48
Зураг 46. Шуудангийн үндсэн үйлчилгээний илгээмж солилцоо, оноор	49
Зураг 47. Нийт ажиллагчдын тоо, оноор	51
Зураг 48. Нийт ажиллагчдын тоо, хүйсээр, 2025 он	52
Зураг 49. Монгол Улсын бүртгэгч байгууллагуудын олгосон нийт домэйн нэрийн тоо, 2021-2025 он.....	53
Зураг 50. Дэд домэйн нэрийн тоо, оноор	54
Зураг 51. Домэйн нэрийн тоо, бүртгэгч байгууллагаар	55
Зураг 52. Идэвхтэй ба идэвхгүй MN, MON домэйн нэрийн тоо, оноор	56

Хавсралт

Хавсралт 1. Хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр, 2025 он.....	57
Хавсралт 2. Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний үндсэн үзүүлэлтүүд, сүүлийн 2 жилээр	58
Хавсралт 3. 2025 оны жилийн эцсийн тайлангийн ирц	59

1. Үндсэн үзүүлэлтүүд

Тусгай зөвшөөрлийн гэрээнд заасны дагуу 2025 оны жилийн эцсийн тайлан мэдээллийг тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2026 оны 2 дугаар сарын 20-ны хугацаанд батлагдсан маягтын дагуу stat.crc.gov.mn цахим системээр цуглуулан авч, үндсэн үзүүлэлтийн тайланг боловсруулсныг танилцуулж байна.

Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 778	Радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл 201	Радио давтамж ашиглах эрхийн бичгийн тоо 748
---	--	--

Нийт орлого 2.7 их наяд ▲ 12.68%	Нийт хөрөнгө оруулалт 427.7 тэрбум ▲ 21.50%	Төсөвт төвлөрүүлсэн орлого 494.7 тэрбум ▲ 28.73%
Хүний нөөц 11,527 ▼ 5.52%	Үүрэн холбооны хэрэглэгч 5,078,278 ▲ 2.36%	Суурин интернэтийн хэрэглэгч 597,491 ▲ 9.39%

Нийт орлогын бүтэц

57.52% Үүрэн холбооны үйлчилгээ	11.33% Олон суваг дамжуулах үйлчилгээ	8.71% Суурин интернэтийн үйлчилгээ	9.47% Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээ	12.97% Бусад
---	---	--	---	------------------------

Хөрөнгө оруулалтын бүтэц

Үүрэн холбооны үйлчилгээ		65.92%
Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээ		14.61%
Суурин интернэтийн үйлчилгээ		6.48%
Бусад		12.99%

Харилцаа холбооны сүлжээ

Сүлжээний төрөл	Урт / Тоо	Тэмдэглэл
Нийт дамжуулах сүлжээ	63,760 км	+19.09%
Хот хоорондын шилэн кабель	45,195 км	44.50% нь МХС ХХК
2025 онд шинээр байгуулсан	4,252 км	Хот хооронд: 519 Хот суурин: 3,733
Интернэтийн гадаад урсгал	830.0 Гбит/сек	+10.67%
Улс хоорондын транзит урсгал	2,430 Гбит/сек	+10.45% (+230 Гбит/сек)

Сансрын холбооны үйлчилгээ


Үйлчилгээний төрөл	Хэрэглэгч / Цэг	Тэмдэглэл
VSAT сүлжээний цэг	64 цэг	
Iridium / Inmarsat үйлчилгээний хэрэглэгч	264	Сансрын хөдөлгөөнт холбоо
Сансрын холбооны интернэт хэрэглэгч	12,112	+105% (2025 оны хагас жилээс)

Үүрэн холбооны үйлчилгээ

5G хэрэглэгч 2,459,108 ▲ 20% (2025 оны хагас жилээс)	4G хэрэглэгч 4,299,394 ▲ 6.48%	3G хэрэглэгч 3,566,812 ▼ 7.01%	2G хэрэглэгч 2,688,596 ▼ 2.30%
Нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) ₮23,798 ▲ 15.8% (+₮3,250)		Ярианы ачаалал 11.3 тэрбум мин ▼ 12.81%	

Дата хэрэглээний өсөлт • 4G дата: 785,345 Терабайт (▲ 10.37%) • 1 хэрэглэгчийн сарын дундаж хэрэглээ: 16.72 Гбайт (▲ 8.35%) • Нийт хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгч: 4,366,236 (▲ 5.53%)	Ухаалаг төхөөрөмж • Нийт ухаалаг төхөөрөмж: 4,408,797 (▲ 1.11%) • Android: 63.05% • iOS (iPhone): 34.32%
--	---

Үүрэн холбооны ухаалаг төхөөрөмж, үйлдлийн системээр



Суурин интернэтийн үйлчилгээ

Суурин интернэтийн нийт хэрэглэгч 597,491 ▲ 9.39%	Суурин интернэтийн ачаалал 2.0 ЕВ ▲ 48.62%	Нэг хэрэглэгчийн сарын дундаж хэрэглээ 279.4 Гбайт ▲ 35.86%	Шилэн кабелийн хэрэглэгч 97.22% ▲ 6.14%
--	---	--	--


Суурин интернэтийн хэрэглэгчийн тоо, хурдаар



Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ

ОСДҮ-ний нийт хэрэглэгч 769,440 ▲ 2.08%	ОТТ үйлчилгээний хэрэглэгч 220,150 ▲ 44.31%
--	--

ОСДҮ хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр



ОСДҮ-ний хэрэглэгчийн тоо, байршлаар

Улаанбаатар хот Нийт хэрэглэгчийн 61.88% ▲6.23% АйПиТВ хэрэглэгч 80.11%	Орон нутаг Нийт хэрэглэгчийн 38.12% ▼4.02% Хиймэл дагуулын хэрэглэгч 52.41%
--	--

Шуудангийн үйлчилгээ

Нийт шуудан солилцоо 3.1 сая ш ▲ 5.74%	Дотоодын шуудан солилцоо 2.2 сая ш ▲ 7.20%	Улс хоорондын шуудан солилцоо 895.5 мян.ш ▲ 2.28%
---	---	--

2. Тусгай зөвшөөрөл

Зохицуулах хорооноос 2025 онд нийт 130 тусгай зөвшөөрөл шинээр олгож, 59 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 42 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ. Хүснэгт 1-д тусгай зөвшөөрлийн шийдвэрийн талаарх мэдээллийг харуулав.


Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн шийдвэрийн мэдээлэл, оноор

Төрөл		2023 он	2024 он	2025 он
Шинээр олгосон	Хуулийн этгээд	117	126	130
	Тусгай зөвшөөрөл	128	145	130
Нэмэлт өөрчлөлт оруулсан	Хуулийн этгээд	17	13	8
	Тусгай зөвшөөрөл	19	19	11
Сэргээсэн	Хуулийн этгээд	19	48	0
	Тусгай зөвшөөрөл	27	60	0
Хугацаа сунгасан	Хуулийн этгээд	104	134	93
	Тусгай зөвшөөрөл	123	160	98
Түдгэлзүүлсэн	Хуулийн этгээд	42	54	53
	Тусгай зөвшөөрөл	47	74	59
Нэр шилжүүлсэн	Хуулийн этгээд	9	3	3
	Тусгай зөвшөөрөл	14	6	4
Хүчингүй болгосон	Хуулийн этгээд	53	71	38
	Тусгай зөвшөөрөл	58	85	42

Эх сурвалж: Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан

2025 оны жилийн эцсийн байдлаар Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нийт 778 болж 24 тусгай зөвшөөрлөөр өссөн, радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах 201 тусгай зөвшөөрөл, радио давтамж ашиглах 748 эрхийн бичиг олгогдсон байгаа нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 1. Зөвшөөрлийн тоо, оноор



Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог ерөнхий чиглэлээр нь авч үзвэл мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр нийт 427, өргөн нэвтрүүлгийн чиглэлээр 235, шуудангийн чиглэлээр 116 тусгай зөвшөөрөл байна.


Хүснэгт 2. Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо, төрлөөр

Чиглэл	Тусгай зөвшөөрлийн төрөл		2023	2024	2025
Мэдээлэл харилцаа холбоо	Харилцаа холбооны сүлжээ байгуулах		20	19	17
	Сансрын холбооны сүлжээ байгуулах		3	3	3
	Харилцаа холбооны үйлчилгээ	Суурин холбоо	7	7	7
		Үүрэн холбоо	5	5	5
		Улс хоорондын яриа	4	4	4
		Суурин интернэт	61	59	61
		Сансрын хөдөлгөөнт холбоо	4	4	4
	Мэдээллийн сүлжээ		6	7	6
	Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ		267	284	320
Нийт		377	392	427	
Өргөн нэвтрүүлэг	Радио, телевизийн газрын сүлжээ		1	1	1
	Олон суваг дамжуулах үйлчилгээ		30	28	26
	Олон нийтийн телевиз		5	5	5
	Өргөн нэвтрүүлгийн телевиз		63	60	56
	Арилжааны телевиз		51	56	58
	Төлбөртэй телевиз		20	22	20
	Олон нийтийн радио		3	4	4
	Арилжааны радио		55	61	65
	Нийт		228	237	235
Шуудан	Шуудангийн сүлжээ байгуулах		12	9	6
	Дотоодын шуудангийн үйлчилгээ	Үндсэн	11	6	6
		Нэмэлт	30	18	16
	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ	Буухиа	10	10	7
		Илгээмж	97	81	81
	Нийт		160	125	116
НИЙТ			765	754	778

3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн нийт орлого 2025 оны байдлаар 2.7 их наядад хүрсэн нь өмнөх оноос 12.67 хувиар, төсөвт төвлөрүүлсэн орлого 494.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 28.74 хувиар тус тус өссөн. Харин нийт хөрөнгө оруулалт 427.7 орчим тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 21.50 хувиар өссөн байна


Зураг 2. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, 2023-2025 он



3.1 Харилцаа холбооны үйл ажиллагааны орлого

Нийт дүнгээр харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого өмнөх оноос 307.1 тэрбумаар буюу 12.68 хувиар өссөн. Нийт орлого 2021 оноос хойш жигд өсөлттэй, сүүлийн 5 жилийн дундаж өсөлт 14.33 хувь байна.

Зураг 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, оноор



Тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний нийт орлогын хамгийн их буюу 57.52 хувийг үүрэн холбооны орлого бүрдүүлж байгаа ба үүрэн холбооны үйлчилгээний орлого 2025 онд өмнөх оноос 13.83 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого,

үйл ажиллагааны чиглэлээр


Чиглэл	Тусгай зөвшөөрлийн төрөл		2023	2024	2025	Өөрчлөлт
			Тэрбум төгрөг			
Мэдээлэл харилцаа холбоо	Харилцаа холбооны сүлжээ байгуулах		243.77	254.79*	258.57	1.48%
	Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ		7.34	7.46	29.69	297.88%
	Харилцаа холбооны үйлчилгээ	Суурин холбоо	33.68	36.29	48.79	16.40%
		Үүрэн холбоо	1,190.79	1,379.02	1,569.68	13.83%
		Улс хоорондын яриа	0.69			
		Суурин интернэт	198.61	204.18	237.72	16.43%
	Мэдээллийн сүлжээ		7.46	7.68	7.82	1.84%
	Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ		62.66	62.35	63.83	2.38%
Өргөн нэвтрүүлэг	Олон суваг дамжуулах үйлчилгээ		212.78	277.2	309.16	11.53%
	Өргөн нэвтрүүлгийн телевиз		61.48	81.04	69.62	-14.10%
	Арилжааны болон төлбөртэй телевиз		34.23	40.80*	45.18	10.74%
	Арилжааны радио		3.92	5.02	5.48	9.13%
Шуудангийн сүлжээ байгуулах, үйлчилгээ эрхлэх			40.69	60.57	83.54	37.93%
НИЙТ			2,098.1	2,422.0	2,729.1	12.68%

3.2 Төсөвт төвлөрүүлсэн орлого

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого¹ 2025 онд 494.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 28.74 хувиар өссөн байна.

Нийт төсөвт төвлөрүүлсэн орлогын хамгийн их буюу 62.13 хувийг үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид бүрдүүлж байна.

Зураг 4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, оноор



¹ Төсөвт төвлөрүүлсэн орлого гэдэгт Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нийгмийн даатгалын шимтгэл, Нэмүү өртгийн албан татвар, Хувь хүний орлогын албан татвар, Гаалийн татвар, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан болон бусад татвар, хураамж хамаардаг.

Хүснэгт 4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, үйл ажиллагааны чиглэлээр

Чиглэл	Тусгай зөвшөөрлийн төрөл		2023	2024	2025	Өөрчлөлт
			Тэрбум төгрөг			
Мэдээлэл харилцаа холбоо	Харилцаа холбооны сүлжээ байгуулах		29.53	24.75	35.68	44.16%
	Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ		0.67	0.71	2.73	284.51%
	Харилцаа холбооны үйлчилгээ	Суурин холбоо	1.93	3.61	8.28	129.36%
		Үүрэн холбоо	223.22	216.64	307.38	41.89%
		Улс хоорондын яриа	0.34			
		Суурин интернэт	9.70	22.70	28.82	26.96%
	Мэдээллийн сүлжээ		1.61	0.04	0.23	475.00%
Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ		10.44	12.31	2.95	5.20%	
Өргөн нэвтрү үлэг	Олон суваг дамжуулах үйлчилгээ		50.81	50.10	56.36	12.50%
	Өргөн нэвтрүүлгийн телевиз		12.74	30.80	14.91	-51.59%
	Арилжааны болон төлбөртэй телевиз		7.77	10.99	10.17	-7.47%
	Арилжааны радио		1.06	1.65	1.52	-7.66%
Шуудангийн сүлжээ байгуулах, үйлчилгээ эрхлэх			6.6	9.99	15.69	57.06%
НИЙТ			356.44	384.29	494.72	28.74%

3.3 Хөрөнгө оруулалт

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчид 2025 онд 428 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь 2024 оны дүнгээс 75.7 тэрбумаар нэмэгдэж 21.51 хувиар өссөн байна. Нийт хөрөнгө оруулалтын 65.92 хувийг (281.8 тэрбум төгрөг) үүрэн холбооны сүлжээ, үйлчилгээнд, 14.61 хувийг (62.5 тэрбум төгрөг) харилцаа холбооны сүлжээ байгуулахад зориулсан байна.

Зураг 5. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, оноор



Хүснэгт 5. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, тусгай зөвшөөрлийн төрлөөр

Чиглэл	Тусгай зөвшөөрлийн төрөл		2023	2024	2025	Өөрчлөлт
			Тэрбум төгрөг			
Мэдээлэл харилцаа холбоо	Харилцаа холбооны сүлжээ байгуулах		32.84	76.19	62.47	-18.01%
	Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ		0.09			
	Харилцаа холбооны үйлчилгээ	Суурин холбоо		2.57	4.21	63.81%
		Үүрэн холбоо	268.41	216.64	281.90	30.12%
		Улс хоорондын яриа				
		Суурин интернэт	2.33	7.19	27.70	285.25%
	Мэдээллийн сүлжээ		0.19	0.60	0.36	-40.00%
Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ		4.02	6.01	3.78	-37.10%	
Өргөн нэвтрү үлэг	Олон суваг дамжуулах үйлчилгээ		0.19	13.67	18.16	32.85%
	Өргөн нэвтрүүлгийн телевиз		3.99	9.15	5.66	-38.14%
	Арилжааны болон төлбөртэй телевиз		1.22	6.83	2.68	-60.76%
	Арилжааны радио		1.14	0.84	0.45	-46.43%
Шуудангийн сүлжээ байгуулах, үйлчилгээ эрхлэх			4.6	12.29	20.29	65.09%
НИЙТ			338.06	351.97	427.66	21.50%

4. Харилцаа холбооны сүлжээ

2025 оны жилийн эцсийн байдлаар Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй (шуудангийн сүлжээг оруулахгүйгээр) нийт 12 аж ахуйн нэгж байна.

Харилцаа холбооны тухай хуульд (2023 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр) нэмэлт өөрчлөлт орсноор Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог ЦХИХХЯ-аас тогтоож², сонгон шалгаруулах журмаар олгохоор зохицуулсан³.

Хүснэгт 6. Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, үйлчилгээний хүртээмжээр, 2025

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Үйлчилгээний хүртээмж
1	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	Хот, хот хооронд/ Улс хооронд /Транзит
2	Мобиком нэтворкс ХХК	Хот, хот хооронд/ Улс хооронд /Транзит
3	Жемнэт ХХК	Хот, хот хооронд/ Улс хооронд /Транзит
4	МТ Нэтворкс ХХК	Хот, хот хооронд/ Улс хооронд /Транзит
5	Айрон товер ХХК*	Хот, хот хооронд

² 6.1.18.зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн Зохицуулах хорооны саналыг харгалзан Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10, 9.11-д заасан тусгай зөвшөөрлийн хувь, хэмжээг тогтоох;"

³ 14.3.Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10, 9.11-д заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулах журмаар олгоно. Сонгон шалгаруулалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

6	Эс Ти Би Эс ХХК	Хот, хот хооронд
7	Скайнэтворкс ХХК	Хот, хот хооронд
8	Скайстрим ХХК*	Хот, хот хооронд/ Улс хооронд/ Транзит
9	Ийзи гөү рөүд ХХК	Хот, хот хооронд/ Улс хооронд
10	Ондо нэтворк ХХК	Хот, хот хооронд
11	Юни трансмишн нэтворк ХХК	Хот, хот хооронд
12	Согно телеком	Хот, хот хооронд

*2025 онд Айрон товер ХХК-ийн үйлчилгээний хүртээмжид өөрчлөлт орж, Улс хоорондын үйлчилгээ нь хасагдсан. Скайстрим ХХК-ийн үйлчилгээний хүртээмжид өөрчлөлт орж, улс хоорондын транзит урсгал дамжуулах үйлчилгээ нэмэгдсэн.


4.1 Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт

Сүлжээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2025 оны нийт орлого 258.6 тэрбум болж өмнөх оноос 1.48 хувиар өссөн байна.

Сүлжээний үйлчилгээний нийт орлогын 67.60 хувийг хот, хот хоорондын сүлжээний үйлчилгээний орлого эзэлж байна.

Хот, хот хоорондын сүлжээний үйлчилгээний орлого өмнөх оноос 1.01 хувиар улс хооронд, транзит үйлчилгээний орлого 2.49 хувиар тус тус өссөн байна.

Зураг 6. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, оноор



Жич: 2024 оны орлогын дүнг залруулсан.

Сүлжээний үйлчилгээнд 62.47 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь өмнөх оноос 18.00 хувиар буурсан байна. 2024 онд 6 компани хөрөнгө оруулалт хийсэн бол 2025 онд 5 компани хөрөнгө оруулалт хийсэн байна.

Хүснэгт 7. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр

Үзүүлэлт	2023	2024	2025	Өөрчлөлт
	Тэрбум төгрөг			
Орлого	243.77	254.79	258.57	1.48 %
Төсөвт төвлөрүүлсэн орлого	29.54	24.75	35.68	44.16%
Хөрөнгө оруулалт	32.83	76.19	62.47	-18.0%

Жич: 2024 оны орлогын дүнг залруулсан.

4.2 Харилцаа холбооны сүлжээний урт

Монгол Улсын дамжуулах сүлжээний урт 63,760 км болж 2024 оноос 19.09 хувиар нэмэгджээ. Үүнээс шилэн кабелийн сүлжээний урт 52,605 км, радио релейний шугамын урт 11,155 км байна.

Хүснэгт 8. Дамжуулах сүлжээний урт (км), төрлөөр

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Шилэн кабелийн сүлжээний урт, км		Радио релейний шугамын урт, км		Нийт урт, км
		Хот хооронд	Хот суурин газарт	Хот хооронд	Хот суурин газарт	
1	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	20,110	127			20,237
2	Скайнэтворкс ХХК	11,421	3,082			14,504
3	Мобиком нэтворкс ХХК	9,988	567	4,462	6,693	21,710
4	Жемнэт ХХК	2,265				2,265
5	МТ Нэтворкс ХХК	1,237				1,237
6	Айрон товер ХХК	134				134
7	Ондо нэтворк ХХК	40				40
8	Юни трансмишн нэтворк ХХК		3,514			3,514
9	Эс Ти Би Эс ХХК		120			120
10	Скайстрим ХХК*		46			46
Нийт урт		45,195	7,456	4,462	6,693	63,760
		52,605		11,155		

*Мэдээллийг нөхөж оруулсан.

Хүснэгт 9. Харилцаа холбооны хот, хот хоорондын дамжуулах сүлжээний урт (км), оноор


№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	2022	2023	2024	2025		
		Нийт			Нийт	Хот хооронд	Хот суурин газар
1	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	19,676	20,026	20,027	20,237	20,110	127
2	Мобиком нэтворкс ХХК	13,064	14,597	17,969*	21,710	14,450	7,260
3	Скайнэтворкс ХХК	12,624	13,440	14,070	14,504	11,421	3,082
4	Юни трансмишн нэтворк ХХК	-	-	-	3,514		3,514
5	Жемнэт ХХК	2,265	2,265	2,265	2,265	2,265	

6	МТ Нэтворкс ХХК	723	1237	1,237	1,237	1,237	
7	Айрон товер ХХК	134	134	134	134	134	
8	Эс ти би эс ХХК	120	120	120	120		120
9	Скайстрим ХХК	-	-	46	46		46
10	Ондо нэтворкс ХХК	40	40	40	40	40	
Нийт урт		48,644	51,939	56,072*	63,760	49,657	14,103

* залруулсан

2025 онд харилцаа холбооны сүлжээ байгуулах тусгай зөвшөөрөлтэй компаниуд хот хооронд 519 км, хот суурин газарт 3,733 км, нийт 4,252 км шилэн кабелийн сүлжээ байгуулж ашиглалтад оруулсан байна.

Зураг 7. Хот хоорондын шилэн кабелийн сүлжээний эзэмшил, 2025




Хот хоорондын шилэн кабелийн үндсэн сүлжээний урт 45,195 км ба үүний 44.50 хувийг төрийн өмчийн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн сүлжээ бүрдүүлж байгаа бол 25.27 хувийг Скайнэтворкс ХХК, 22.10 хувийг Мобиком нэтворкс ХХК-ийн байгуулсан сүлжээ тус тус бүрдүүлж байна.

4.3 Улс хоорондын сүлжээний үйлчилгээ

Монгол Улсын хэмжээнд харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд улс хоорондын сүлжээний үйлчилгээ үзүүлэгч компаниуд БНХАУ, ОХУ, Хонгконг, АНУ, ХБНГУ, Япон улсын компаниудаар дамжуулан Ази, Европын үндсэн порттой шууд холбогдож, интернэтийн бөөний урсгалын үйлчилгээг үзүүлж байна.

Интернэтийн гадаад урсгалын багтаамж 2025 оны жилийн эцэст 830.0 Гбит/сек болсон нь 2024 оны жилийн эцсийн үеэс 80.0 ГБит/сек-ээр буюу 10.67 хувиар нэмэгджээ. Харин интернэтийн үйлчилгээ эрхлэгчдэд гэрээлсэн урсгал 275.3 Гбит/сек ба 2024 оны жилийн эцсээс 20.36 хувиар нэмэгдсэн байна.

**Зураг 8. Интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгчдийн нийт урсгалын багтаамж:
Гбит/сек**



2025 оны байдлаар нийт 50 интернэтийн үйлчилгээ эрхлэгч (давхардсан тоогоор) улс хоорондын сүлжээ эзэмшигчдээс 275.3 Гбит/сек гадаад интернэтийн урсгал түрээслэж байна. Түрээслэж байгаа урсгалын хэмжээ нь өмнөх оноос 20.36 хувиар нэмэгджээ.

4.4 Улс хоорондын транзит үйлчилгээ

Улс хооронд транзит урсгал түрээслүүлэх үйлчилгээг Жемнэт ХХК, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Мобиком нэтворкс ХХК-иуд үзүүлж, нийт 2,430 Гбит/сек урсгалыг түрээслүүлж байна.

Түрээслүүлж буй транзит урсгалын хэмжээ өмнөх оноос 10.45 хувиар өссөн бол тус үйлчилгээний орлого 2025 онд 26.94 тэрбум төгрөг болж өмнөх оноос 22.51 хувиар өссөн байна.

Хүснэгт 10. Улс хоорондын нийт транзит урсгал ба орлогын хэмжээ, оноор

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Урсгалын хэмжээ, Гбит/сек	750	780	1370	1700	1800	2200	2430
Орлого Тэрбум төгрөг	17.3	18.4	22.0	28.8	26.4	22.99	26.94

4.5 Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ

Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 4 аж ахуйн нэгж, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд сансрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээг 3 аж ахуйн нэгж эзэмшиж, сүлжээний түрээс, яриа, интернэтийн үйлчилгээ үзүүлж байна.

Эдгээр сансрын холбооны үйлчилгээ эрхлэгчдийн үйлчилгээний орлого 2025 онд өмнөх оноос 3.9 дахин өссөн байна.

Хүснэгт 11. Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэгчдийн орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр

Үзүүлэлт	2023	2024	2025	Өөрчлөлт
	Тэрбум төгрөг			
Орлого	7.33	7.46	29.69	298.03%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	0.67	0.71	2.73	285.14%
Хөрөнгө оруулалт	0.09	-	-	

2023 онд Старлинк Сервисес Монголиа ХХК харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авч, нам орбитын хиймэл дагуулын сүлжээгээр интернэтийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн. Старлинк үйлчилгээний хэрэглэгч 12,112 болж, 2025 оны хагас жилтэй харьцуулахад 105 хувиар өссөн.

Хүснэгт 12. Сансрын холбооны интернэт хэрэглэгчийн тоо, оноор

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
1	Исатком ХХК	438	366	366	285	-
2	Старлинк сервисес Монголиа ХХК				1,497	12,112

Сансрын хөдөлгөөнт холбооны ярианы (Иридиум, Инмарсат эм) үйлчилгээний нийт 267 хэрэглэгч байна.

5. Үүрэн холбооны үйлчилгээ

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үүрэн холбооны яриа, мессеж болон интернэт үйлчилгээг 5 компани үзүүлж байна. 2025 онд тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн нийт орлогын 57.52 хувь, хөрөнгө оруулалтын 65.92 хувийг үүрэн холбооны компаниуд бүрдүүлжээ.

Монгол Улс үүрэн холбооны үйлчилгээний 3G технологийг 2008 онд, 4G технологийг 2016 онд зах зээлд нэвтрүүлж байсан бол 5G технологийн туршилтыг 2022 онд эхлүүлж, 2025 онд зах зээлд албан ёсоор нэвтрүүллээ.


Хүснэгт 13. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд эзлэх хувь

Тусгай зөвшөөрөл эзэмшигч	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Мобиком корпораци ХХК	37.80%	38.03%	38.17%	38.30%	37.95%	36.85%	36.55%	36.27%
Скайтел ХХК	16.51%	17.43%	18.06%	17.65%	17.50%	18.62%	17.66%	18.36%
Юнител ХХК	34.03%	33.08%	32.20%	34.34%	34.04%	32.24%	32.50%	31.66%
Жи-Мобайл ХХК	11.66%	11.46%	11.58%	9.71%	9.66%	9.49%	9.41%	9.56%
Ондо ХХК					0.85%	2.80%	3.88%	4.14%

5.1 Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт

2025 оны жилийн эцсийн байдлаар үүрэн холбооны үйлчилгээний орлого 1.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 13.83 хувиар өсчээ.

Зураг 9. Үүрэн холбооны үйлчилгээний орлого, оноор



Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид 2025 онд 281.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь өмнөх оноос 30.12 хувиар өссөн бол 307.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өмнөх оноос 41.89 хувиар өссөн байна.

Хүснэгт 14. Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр

Үзүүлэлт	2023	2024	2025	Сүүлийн жилийн өөрчлөлт
	Тэрбум төгрөг			
Орлого	1,190.78	1,379.02	1,569.68	13.83%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	223.22	273.70	307.38	41.89%
Хөрөнгө оруулалт	268.41	216.64	281.89	30.12%

2007 онд үүрэн холбооны үндсэн үйлчилгээний орлогын 90 орчим хувийг ярианы үйлчилгээ дангаар эзэлж байсан бол 2008 оноос хойш өндөр хурдны 3G үйлчилгээ, 2016 онд LTE үйлчилгээ нэвтэрснээс хойш хэрэглэгчийн хандлага ярианаас дата үйлчилгээ рүү шилжиж, жилээс жилд ярианы үйлчилгээний орлого буурч, дата үйлчилгээний орлого өсч байна.


Хүснэгт 15. Үүрэн холбооны үндсэн үйлчилгээний орлого, оноор

Орлогын бүтэц	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
	Нийт орлогод эзлэх %							
Ярианы үйлчилгээ	38.70	37.55	36.67	34.29	35.35	24.35	24.80	22.66
Дата үйлчилгээ	21.60	25.00	28.27	32.35	31.26	42.98	43.72	47.01
Мессеж үйлчилгээ	6.71	4.10	3.85	3.35	3.79	3.18	1.34	1.46
Харилцан холболт	7.89	7.08	7.20	6.90	6.15	5.40	4.84	4.01
Дамжуулан холболт	0.01	0.01	0.02	0.02	0.01	0.01	0.01	0.01
Нэмэлт үйлчилгээ	4.32	4.26	5.01	4.61	3.96	3.53	3.36	3.33

Улс хоорондын роуминг	0.99	1.10	0.18	0.12	0.28	0.72	1.34	1.41
Гар утас, модем	12.42	13.52	11.06	11.51	11.97	12.63	13.16	12.83
Бусад	7.36	7.37	7.75	6.85	7.22	7.19	7.43	7.29

Үүрэн холбооны нэг хэрэглэгчээс олох дундаж орлого 23,798 төгрөг болж, 2024 оноос 3,250 төгрөгөөр нэмэгджээ.

Зураг 10. Үүрэн холбооны нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU)




5.2 Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо

Үүрэн холбооны нийт идэвхтэй хэрэглэгч 2025 оны жилийн эцсийн байдлаар **5,078,278** болж өмнөх оноос 2.36 хувиар нэмэгдсэн бол 100 хүнд ногдох үзүүлэлт нь 141.5 болж өмнөх оноос 3.6 нэгжээр өссөн байна.

Энэ үзүүлэлт нь дэлхийн орнуудын дундажтай харьцуулахад Монгол Улсын хувьд харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Зураг 11. Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо, оноор




Хүснэгт 16. Үүрэн холбооны нэвтрэлтийн түвшин

	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дэлхийн дундаж	101	103	105	106	105	106	108	110.6	112	112
Монгол улс	110.7	125.2	133.3	136.7	132.6	140.4	142.8	141.1	140.7	141.5

Эх сурвалж: ITU DataHub

Үүрэн холбооны нийт хэрэглэгчийн 56.92 хувийг урьдчилсан төлбөрт, 30.12 хувийг дараа төлбөрт, 12.96 хувийг хосолсон төлбөрт хэрэглэгч эзэлж байгаа бөгөөд жил ирэх бүр үүрэн холбооны хэрэглээ дараа болон хосолсон төлбөрт үйлчилгээ рүү бага багаар шилжиж байна.

Зураг 12. Хэрэглэгчийн төлбөрийн нөхцлөөр зах зээлд эзлэх хувь, оноор



Үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын интернэт хэрэглэгчийн тоо 4,366,236 болж өмнөх оноос 5.53 хувиар өссөн. Энэ нь үүрэн холбооны нийт хэрэглэгчийн 85.98 хувь нь интернэт хэрэглэж байгааг харуулж байна. Үүнээс зөвхөн дата (data only) хэрэглэдэг хэрэглэгчийн тоо 472,382 болж, 2024 онтой харьцуулахад 27.50 хувиар өссөн байна.

Хүснэгт 17. Хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоо, оноор


Он	Дата ба яриа хосолсон	Зөвхөн дата (Only data)	Нийт
2020	3,353,188	226,583	3,579,771
2021	3,633,268	255,971	3,889,239
2022	3,644,821	352,079	3,996,900
2023	3,751,283	371,083	4,122,366
2024	3,766,868	370,485	4,137,353
2025	3,893,854	472,382	4,366,236

Үүрэн холбооны 3G сүлжээ Монгол Улсын 345 сум, суурин газарт нэвтэрсэн бөгөөд 3G хэрэглэгчийн тоо 2025 оны жилийн эцсийн байдлаар 3.6 сая байгаа нь 2024 онтой харьцуулахад 7.1 хувиар буурсан байна.

Харин 4G/LTE сүлжээ нийт хүн амын 99 хувийг хамарч, үйлчилгээний хэрэглэгчийн тоо 4.3 саяд хүрч, өмнөх оноос 6.5 хувиар өссөн.

Үүрэн холбооны 5G үйлчилгээ 2025 оны 5 сард зах зээлд нэвтэрсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар 5G сүлжээнд бүртгэгдсэн хэрэглэгч 2,459,108 болсон нь 2025 оны хагас жилтэй харьцуулахад 20 хувиар өсчээ.

Зураг 13. 3G, 4G/LTE, 5G хэрэглэгчийн тоо



Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид LTE сүлжээнд смарт бокс ашигласан (“Гэр”, “Манай”, “Скайнэт” зэрэг) интернэт үйлчилгээг хэрэглэгчид санал болгож буй бөгөөд тэдгээр хэрэглэгчийн тоо 2025 оны байдлаар 115,891 байгаа нь өмнөх оноос 12.33 хувиар буурсан байна. Харин 5G үйлчилгээ нэвтэрсэнээр үйлчилгээ эрхлэгчид зах зээлд “5G Home”, “5G гэр интернэт” зэрэг утасгүй суурин (5G FWA) интернэт нэвтрүүлж, хэрэглэгчийн тоо нь 11,886 хүрсэн байна.

Хүснэгт 18. Хөдөлгөөнт өргөн зурвасын смарт бокс ашиглан үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоо

	2019	2020	2021	2022	2023	2024	2025
LTE/Wimax	102,185	114,602	136,030	133,851	135,223	132,197	115,891
5G (FWA)							11,886


Үүрэн холбооны сүлжээ

Үүрэн холбооны сүлжээ жил ирэх бүр хүрээгээ тэлж бааз станцын тоо нийт дүнгээр өмнөх оноос 13.65 хувиар нэмэгджээ. Нийт бааз станцын 58.43 хувийг 4G сүлжээний, 19.61 хувийг 3G сүлжээний, 16.75 хувийг 2G сүлжээний, 5.20 хувийг 5G сүлжээний бааз станц бүрдүүлж байна.

Хүснэгт 19. Үүрэн холбооны бааз станцын тоо, технологийн төрлөөр

Он	2G	3G	4G	5G	Нийт
2020	2,480	2,691	3,656		8,827
2021	2,734	2,980	4,344		10,058
2022	2,753	3,128	5,769		11,650
2023	2,969	3,453	8,471		14,893
2024	3,135	3,469	9,724		16,328
2025	3,109	3,639	10,843	965	18,556

Зураг 14. Үүрэн холбооны бааз станцын тоо, технологийн төрлөөр




Үүрэн холбооны нийт хэрэглэгч болон 3G, 4G/LTE хэрэглэгчийн тоог Улаанбаатар хот, аймаг, бүс нутгийн хүн амын тоотой харьцуулахад 4G/LTE хэрэглэгчийн нэвтрэлт баруун бүсэд хамгийн бага буюу 90.51 хувьтай байгаа бол Улаанбаатар хотод 119.72 хувьд хүрсэн байна.


Хүснэгт 20. Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо бүс, байршлаар, 2025 он

Байршлаар	Хүн ам	Үүрэн холбоо	2G	3G	4G/LTE	5G
НИЙТ	3,591,120	5,078,278	2,688,596	3,566,812	4,299,394	2,459,108
		141.41%	74.87%	99.32%	119.72%	68.48%
БАРУУН БҮС	426,062	485,675	258,391	292,947	385,642	183,049
БАЯН-ӨЛГИЙ	119,344	107,235	65,003	57,089	96,295	61,342
ГОВЬ-АЛТАЙ	56,831	71,934	41,170	49,653	54,902	23,701
ЗАВХАН	71,049	107,173	41,866	52,059	66,142	18,910
УВС	85,396	94,147	49,629	62,059	79,750	29,329
ХОВД	93,442	105,186	60,723	72,087	88,553	49,767
ХАНГАЙН БҮС	607,553	701,438	407,569	501,139	581,267	260,930
АРХАНГАЙ	92,580	104,920	61,206	69,260	81,348	31,795
БАЯНХОНГОР	89,339	103,447	65,119	72,837	83,923	27,795
БУЛГАН	60,630	65,868	39,544	51,296	55,567	26,355
ОРХОН	111,492	134,050	75,943	107,500	125,441	88,706
ӨВӨРХАНГАЙ	115,634	124,888	67,170	93,738	103,780	47,399
ХӨВСГӨЛ	137,878	168,265	98,587	106,508	131,208	38,880
ТӨВИЙН БҮС	529,919	751,698	434,556	566,423	660,446	348,878
ГОВЬСҮМБЭР	18,758	22,355	13,831	15,418	19,980	12,214
ДАРХАН -УУЛ	111,244	142,758	73,901	108,541	131,046	94,208
ДОРНОГОВЬ	72,515	119,326	60,026	84,845	98,965	39,403
ДУНДГОВЬ	46,577	58,693	30,880	41,186	43,630	14,540
ӨМНӨГОВЬ	79,055	172,177	110,252	137,284	158,271	76,401
СЭЛЭНГЭ	107,713	115,917	68,280	86,860	106,996	69,064
ТӨВ	94,057	120,472	77,386	92,289	101,558	43,048
ЗҮҮН БҮС	231,541	307,767	158590	209,014	238,944	85,653
ДОРНОД	84,991	105,993	65,407	78,516	89,071	38,171
СҮХБААТАР	66,611	83,074	39,806	56,078	68,018	22,772
ХЭНТИЙ	79,939	118,700	53,377	74,420	81,855	24,710
УЛААНБААТАР	1,796,045	2,831,700	1,429,490	1,997,289	2,433,095	1,580,598
		157.66%	79.59%	111.20%	135.47%	88.00%

Зураг 15. Үүрэн холбооны 3G нэвтрэлтийн хувь, аймагаар, 2025 он




Зураг 16. Үүрэн холбооны 4G/LTE нэвтрэлтийн хувь, аймагаар, 2025 он.



Үүрэн холбооны сүлжээн дэх машин буюу төхөөрөмжийн (M2M) тоо 213,012 болсон нь өмнөх оноос 11.53 хувиар өссөн байна.


Зураг 17. M2M хэрэглэгчийн тоо, оноор



“M2M хэрэглэгч” гэж машин буюу төхөөрөмж хооронд (автомашины GPS, ТҮЦ машин, төлбөр тооцооны PoS машин, камер, ухаалаг тоолуур, гэрийн ухаалаг төхөөрөмжүүд гм), хүний оролцоогүйгээр өрөгдөл дамжуулах зорилгоор ашиглаж буй сим карт буюу хэрэглэгчийн тоо юм. M2M мобайл сүлжээ хэрэглэгч нь ямар нэг хувь хүнд хамаарахгүй, тухайн төхөөрөмжийг хэд хэдэн хүн ашиглах боломжтой байдгаараа онцлогтой.

Ухаалаг төхөөрөмж хэрэглэгчийн тоо 2025 оны жилийн эцсийн байдлаар **4,408,797**-д хүрч өмнөх оноос 1.10 хувиар өссөн байна. Хэрэглэгчийн ухаалаг төхөөрөмжийн 63.05 хувийг Андроид, 34.32 хувийг Apple IOS үйлдлийн систем бүхий төхөөрөмж эзэлж байгаа бөгөөд Apple IOS төхөөрөмжийн хэрэглээ өмнөх оноос 2.10 хувиар өсчээ.

Зураг 18. Ухаалаг төхөөрөмж хэрэглэгчийн тоо




5.3 Үүрэн холбооны ачаалал

5.3.1 Ярианы ачаалал

Үүрэн холбооны сүлжээн дэх ярианы нийт ачаалал 11.03 тэрбум минут болж 2024 онтой харьцуулахад 12.81 хувиар буурсан. Сүлжээн доторх ярианы ачаалал 13.48 хувиар буурсан бол гарах ачаалал 11.85 хувь, орох ачаалал 12.41 хувь болж тус тус буурсан байна.

Зураг 19. Үүрэн холбооны сүлжээн дэх ярианы ачаалал, сая минут




Үүрэн сүлжээн дэх ярианы нийт ачааллыг хэрэглэгчийн тоотой харьцуулж тооцоолоход үүрэн холбооны нэг хэрэглэгч хоногт дунджаар 6.13 минутын ярианы ачаалал үүсгэсэн байна.

5.3.2 Мессеж ба дата хэрэглээ

Үүрэн холбооны сүлжээнд илгээсэн мессеж жил буурах хандлагатай байгаа ч 2025 онд илгээсэн мессеж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.84 хувиар өссөн байна. Хэрэглэгчийн тоотой харьцуулбал үүрэн холбооны нэг хэрэглэгч сард дунджаар 10.6 мессеж илгээсэн байна.

Зураг 20. Үүрэн холбооны сүлжээнд илгээсэн мессеж, сая ширхэг




Үүрэн холбооны хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээ 2025 оны жилийн эцсийн байдлаар 875,887 Терабайтад хүрч, нийт дата хэрэглээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.35 хувиар өссөн байна.

3G сүлжээн дэх дата хэрэглээ 52,590 Терабайт болж өмнөх онтой харьцуулахад 3.33 хувиар буурсан бол 4G сүлжээнд 785,345 Терабайт болж 10.37 хувиар тус тус өсчээ. 5G сүлжээнд 35,951 Терабайт дата хэрэглээ үүссэн байна. Дата хэрэглээ жил бүр өсч байгаа ч нийт өсөлтийн хувь 2024 онтой харьцуулахад 1.46 нэгж хувиар буурчээ.

2025 онд нэг хэрэглэгчийн нэг сарын дундаж дата хэрэглээ 16.72 Гбайт байгаа нь 2024 онтой харьцуулахад 1.29 Гбайтаар (8.35 хувь) нэмэгджээ.

Зураг 21. Хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн дата ачаалал, технологийн төрөл, оноор - Терабайт (TB)



4G сүлжээнд үүсгэсэн нэг хэрэглэгчийн дундаж дата хэрэглээ өмнөх оноос 0.5 Гбайтаар өссөн байна.

Хүснэгт 21. Үүрэн холбооны үйлчилгээний нэг хэрэглэгчийн сарын дундаж дата хэрэглээ

ОН	3G			4G		
	Хэрэглэгч	Дата хэрэглээ	Нэг хэрэглэгчийн 1 сарын дундаж хэрэглээ /GB/	Хэрэглэгч	Дата хэрэглээ	Нэг хэрэглэгчийн 1 сарын дундаж хэрэглээ /GB/
2018	2,515,800	34,157,518	1.1	1,473,300	34,578,336	2
2019	3,190,500	43,010,021	1.1	1,956,800	102,903,673	4.4
2020	3,294,300	50,291,174	1.3	2,365,100	212,004,218	7.5
2021	3,539,362	48,883,129	1.2	2,809,592	356,579,612	10.6
2022	3,559,582	41,425,077	1.0	3,093,666	474,596,487	12.8
2023	3,575,115	49,116,903	1.1	3,447,287	612,278,731	14.8
2024	3,838,038	54,402,847	1.2	4,037,902	711,577,131	14.7
2025	3,566,812	52,590,330	1.2	4,299,394	785,345,396	15.2

6. Суурин интернэт үйлчилгээ

Суурин интернэтийн үйлчилгээ эрхэлж буй 61 тусгай зөвшөөрөл эзэмшигч (ISP) байгаагаас 29 нь Монгол Улс, 14 нь Улаанбаатар, 18 нь аймаг сумын хамрах хүрээ бүхий тусгай зөвшөөрөлтэй байна.

Идэвхтэй гэрээт хэрэглэгчийн тоогоор зах зээлд эзлэх хувийг нийт Монгол Улс, Улаанбаатар хот болон орон нутагт гэж тооцвол 6 компани нийт зах зээлийн 98.8 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 22. Суурин интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Монгол Улс		Улаанбаатар		Орон нутаг	
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
1	Юнивишн ХХК	457,336	76.54%	339,227	76.89%	118,109	75.57%
2	Скаймедиа корпораци ХХК	56,717	9.49%	48,897	11.08%	7,820	5.00%
3	Мобинет ХХК	38,974	6.52%	23,808	5.40%	15,166	9.70%
4	Монголын цахилгаан холбоо ХК	15,578	2.61%	3,978	0.90%	11,600	7.42%
5	Эн Би Си ХХК	11,968	2.00%	9,349	2.12%	2,619	1.68%
6	Кевико ХХК	9,721	1.63%	9,600	2.18%	121	0.08%
	Нийт	590,294	98.80%	434,859	98.56%	155,435	99.45%


6.1 Суурин интернэт үйлчилгээний орлого

Суурин интернэт үйлчилгээний орлого 2024 онд өмнөх оноос 2.8 хувиар өсч 204.2 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт харилцаа холбооны үйлчилгээний орлогын 8.48 хувийг эзэлж байна.

Хүснэгт 23. Суурин интернэт үйлчилгээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 4 жилээр


Үзүүлэлт	2023	2024	2025
	Тэрбум төгрөг		
Орлого	198.61	204.18	237.72
Төсөвт төвлөрүүлсэн орлого	9.70	22.70	28.82
Хөрөнгө оруулалт	2.33	7.19	27.70

Зураг 22. Суурин интернэт үйлчилгээний нийт орлого



Суурин интернэт үйлчилгээний нийт орлогын 56.14 хувийг өрх, 2.15 хувийг төсвийн байгууллага, 41.71 хувийг аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчээс бүрдүүлж байна.


Зураг 23. Интернэтийн үйлчилгээний орлогын бүтэц, 2025 он



6.2 Суурин интернэт хэрэглэгчийн тоо

Монгол Улсын хэмжээнд суурин интернэтэд холбогдсон буюу гэрээт хэрэглэгчийн тоо 2025 оны жилийн эцсийн байдлаар 597,491 -д хүрч өмнөх оноос 9.39 хувиар өссөн байна.

Зураг 24. Суурин интернэт хэрэглэгчийн тоо




Суурин интернэт хэрэглэгчийг байршлаар нь авч үзвэл 88.95 хувь нь Улаанбаатар хотод, 29.68 хувь нь орон нутагт байна. Суурин интернэт хэрэглэгчийн тоо Улаанбаатар хотод 7.62 орон нутагт 14.69 хувиар тус тус нэмэгджээ.

Зураг 25. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, байршлаар




Суурин интернэт хэрэглэгчийн 97.22 хувь нь өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ, үлдсэн 2.78 хувь нь Wi-Fi, Wi-MAX, DSL -ийн холболттой байна.

Зураг 26. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр



2025 оны жилийн эцсийн байдлаар нийт хэрэглэгчийн 96.18 хувь нь 10 Мбит/сек-ээс дээш хурдаар үйлчилгээ авч байна.

Зураг 27. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, гэрээт хурдаар



Хүснэгт 24. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, оноор, гэрээт хурдаар

Хурдаар	2021	2022	2023	2024	2025
256 Kbit/s-2Mbit/s	11,350	17,456	8,923	3,731	4,233
2Mbit/s-10Mbit/s	117,958	50,383	56,438	20,633	18,593
10Mbit/s-30Mbit/s	113,505	151,258	172,028	213,390	225,210
30Mbit/s-100Mbit/s	136,128	214,572	257,895	300,751	338,465
>100Mbit/s	1,286	2,778	3,605	7,708	10,990
Нийт	380,227	436,447	498,889	546,213	587,491

Нийт интернэтийн хэрэглэгчийн 93.51 хувь нь өрхийн хэрэглэгч бөгөөд улсын хэмжээнд өрхийн тоотой харьцуулбал нэвтрэлт 59.09 хувь, Улаанбаатар хотод 89.95 хувь, аймгуудаас хамгийн өндөр нь Орхон аймаг 80.86 хувьтай, харин хамгийн бага нь Завхан аймаг 12.69 хувьтай байна.

Хүснэгт 25. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр


Аймаг, хот	Хэрэглэгчийн тоо			Өрхийн тоо*	Өрхийн нэвтрэлт
	Нийт	Өрхийн	Байгууллагын		
НИЙТ	597,491	558,700	38,791	1,011,078	59.09%
УЛААНБААТАР	441,199	412,568	28,631	490,501	89.95%
БАРУУН БҮС	21,987	20,184	1,803	111,426	19.73%
БАЯН-ӨЛГИЙ	4,275	3889	386	26,382	16.20%
ГОВЬ-АЛТАЙ	3,935	3673	262	16,359	24.05%
ЗАВХАН	2,739	2449	290	21,586	12.69%
УВС	4,671	4276	395	22,805	20.48%
ХОВД	6,367	5897	470	24,294	26.21%
ХАНГАЙН БҮС	54,290	51,312	2,978	178,698	30.38%
АРХАНГАЙ	4,226	3842	384	27,386	15.43%
БАЯНХОНГОР	6,788	6374	414	26,956	25.18%
БУЛГАН	3,484	3132	352	19,106	18.24%
ОРХОН	24,661	23728	933	30,500	80.86%
ӨВӨРХАНГАЙ	6,973	6519	454	34,449	20.24%
ХӨВСГӨЛ	8,158	7717	441	40,301	20.24%
ТӨВИЙН БҮС	62,064	57,757	4,307	158,704	39.11%
ГОВЬСҮМБЭР	2,651	2500	151	5,446	48.68%
ДАРХАН -УУЛ	21,755	20657	1,098	30,705	70.85%
ДОРНОГОВЬ	9,166	8604	562	21,861	41.93%
ДУНДГОВЬ	2,635	2395	240	14,904	17.68%
ӨМНӨГОВЬ	11,051	9697	1,354	27,105	40.77%
СЭЛЭНГЭ	9,979	9519	460	29,932	33.34%
ТӨВ	4,827	4385	442	28,751	16.79%
ЗҮҮН БҮС	17,951	16879	1072	71,749	25.02%
ДОРНОД	9,696	9236	460	25,820	37.55%
СҮХБААТАР	3,287	3006	281	19,882	16.53%
ХЭНТИЙ	4,968	4637	331	26,047	19.07%

**Эх сурвалж: 2025 оны байдлаар өрхийн тоог 1212.тн-ээс*

6.3 Суурин интернэтийн хэрэглээ

